

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ: ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Д.Начин*

Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбрийг хэрэгжүүлэх, эдийн засгийн гадаад харилцааг тогтвортой хөгжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, нэр төрлийг нь олшруулах, үр ашгийг нь дээшлүүлэхэд үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалуудад тулгуурлан гадаад харилцааны бодлого чиглэгдэж байна. Дипломат албаны тухай Монгол Улсын хуульд *...улс орны аюулгүй байдал, үндэсний хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх, ... гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагааг эдийн засаг, шинжлэх ухаан, техник, худалдаа, хүмүүнлэгийн хамтын ажиллагаатай уялдуулан зохицуулах* (МУЗГ, 2000) зэрэг заалтууд нь энэ чиглэлээр дипломат үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа юм.

Монгол улсын төр, засгаас гадаадын хөрөнгө оруулалтад өндөр ач холбогдол өгсөөр ирсэн бөгөөд тэр нь Монгол улсын Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, бусад хууль, тогтоомж болон Монгол улсын нэгдэн орсон олон улсын болон хоёр талын гэрээ, хэлэлцээрээр баталгаажин хамгаалагдсан байдаг юм.

Монгол Улсын олон улсын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа нь түүний нэгдэн орсон олон улсын дараахи олон талт гэрээ хэлэлцээрүүдээр зохицуулагддаг байна. Үүнд: 1996 онд нэгдэн орсон “Улс болон бусад улсын иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай” 1965 оны Вашингтоны конвенци, 1997 онд нэгдэн орсон “Олон талын Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллагын (1985 оны) конвенци”, 1997 онд нэгдэн

* Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн ахлах мэргэжилтэн, МУИС-ийн ОУХС-ийн докторант, Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж -38, Улаанбаатар 211238, Монгол Улс, Утас: 976-11-326040, Факс: 976-11-324076, и-мэйл: nachin@investmongolia.com

орсон “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр”, “Олон улсын бараа худалдах, худалдан авах тухай Венийн конвенци”, 1985 онд нэгдэн орсон “Аж үйлдвэрийн өмчийн эрхийг хамгаалах тухай (Парисын 1883 оны) конвенци”, “Барааны тэмдгийн Олон улсын бүртгэлийн тухай (Мадридын 1891 оны) хэлэлцээр”, 1991 онд нэгдэн орсон “Патентын хамтын ажиллагааны (1970 оны) гэрээ”¹ зэргийг дурьдаж болно.

Монгол улсын Засгийн газар нь “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” хоёр талын хэлэлцээрт 31 улстай, “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т 37 улстай тус тус гарын үсэг зурсан.

Монгол Улсын Засгийн газраас байгуулсан Худалдааны гэрээ хэлэлцээрүүд, ялангуяа АНУ, Европын Холбоотой байгуулсан худалдааны нэн тааламжтай гэрээнүүд нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал нөлөө үзүүлж байгаа болно. Монгол улс нь Дэлхийн банкны Олон талын Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах агентлагийн/MIGA/ гишүүн учир хөрөнгө оруулагчид MIGA-ийн эрсдлийн даатгалд хамрагдах эрхтэй гэдгийг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

Монгол улсын Засгийн газраас хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй, тогтвортой, эрх тэгш, харилцан ашигтай зарчимд тулгуурласан өргөн цар хүрээтэй хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэх талаар явуулсан бодлого үйл ажиллагаа тодорхой үр дүнгээ өгч байна.

Манай улс ОХУ-тай харилцаа, хамтын ажиллагаагаа “сайн хөршийн уламжлалт түншлэл”-ийн үзэл санааны дагуу явуулж байна.² Монгол улсын Засгийн газар нь ОХУ-ын Засгийн газартай 1995 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, 1995 оны 4

¹ Дүгэрсүрэн М., Хосбаяр О., 1999, Олон улсын эрх зүй, 1999, МУИС, Олон улсын харилцааны дээд сургууль, Улаанбаатар, Монгол Улс

² Гадаад хэргийн яам (ГХЯ), 2004, Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны салбарын 2000-2004 оны үйл ажиллагааны тухай сайд Л.Эрдэнэчулуунаас сэтгүүлчдэд хийсэн мэдээлэл, 2004.03.16., Улаанбаатар

³ Гадаад хэргийн яам (ГХЯ), 2004, Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны салбарын 2000-2004 оны үйл ажиллагааны тухай сайд Л.Эрдэнэчулуунаас сэтгүүлчдэд хийсэн мэдээлэл, 2004.03.16., Улаанбаатар

⁴ Мөн тэнд

⁵ Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА) 2004, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тойм 2002, 2003. ГХОГХА, Улаанбаатар

дүгээр сарын 5-ны өдөр “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” гэрээнд тус тус гарын үсэг зурсан бөгөөд давхар татварын гэрээ нь 1998 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон байна.

Идэвхгүй байдалд ороод байсан Монгол-Оросын харилцааг чапарын шинэ шатанд гаргаж, олон жилийн туршид шийдлээ хүлээж байсан томоохон асуудлуудыг нааштайгаар зохицуулхад ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины 2000 онд, ОХУ-ын Засгийн газрын дарга М.Касьяновын 2002 онд манай улсад хийсэн айлчлалууд, Монгол улсын Ерөнхий сайдын 2003 онд ОХУ-д хийсэн айлчлал нь чухал үүрэг гүйцэтгэж, хоёр улсын харилцаанд гарсан нааштай эхлэлийг улам батжуулан, Монгол-Оросын хамтын ажиллагаанд олон жилийн турш шийдвэрлэгдэлгүй хуримтлагдсан “их өр”-ийн гэгдэх асуудлыг нааштай шийдвэрлэхэд бодитой нөлөө үзүүлсэн бөгөөд энэ нь хоёр талын улс төр, эдийн засгийн харилцаанд цоо шинэ уур амьсгал бий болгов.³

Оросын тал “Эрдэнэт” үйлдвэр, “Монголросцветмет” нэгдлийг байгуулахад зориулж Монгол улсад олгосон зээлийг 2003 онд хүчингүй болгосон ба ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн орон сууцны тодорхой тооны байшинг Монголын талд үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн. 2003 онд хоёр орны гадаад худалдааны нийт эргэлт 306.6 сая ам.долларт хүрч, үүний 265.4 сая нь импортод ногдож байгаа⁴ ба ОХУ-ын Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орохтой холбогдуулж хоёр талын хэлэлцээр хийгдэж байгаа болно.

ОХУ-ын хөрөнгө оруулагчид Монголд нийтдээ 34 сая орчим ам.долларын хөрөнгө оруулсан нь Монголд орсон нийт гадаадын хөрөнгө оруулалтын 3.3 орчим хувийг бүрдүүлж байна. (Энд 1990 оноос хөрөнгө оруулалт ороогүй болохыг анхаарна уу.) Энэ хугацаанд ОХУ-ын хөрөнгө оруулагчид 380 хамтарсан болон дагнасан компани бүртгүүлсэн байна.

ОХУ нь бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ 6 дугаарт, компанийн тоогоороо 3 дугаарт орж байна. ОХУ-аас уул уурхай /7.8 сая ам.доллар/, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /5.2 сая ам.доллар/, банк санхүү /4.1 сая ам.доллар/, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл /3.1 сая ам.доллар/-ийн

³ Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА) 2004, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тойм 2002, 2003. ГХОГХА, Улаанбаатар

салбаруудад түлхүү хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын томоохон хөрөнгө оруулагч бөгөөд салбарын гадаадын хөрөнгө оруулалтын 11.3 хувийг оруулсан байна. 2003 оны хувьд хөрөнгө оруулалтын хэмжээ 2002 оныхоос 61 хувиар өсч 2,5 сая ам. долларт хүрсэн байна.⁵

Монгол-Хятадын харилцаа, хамтын ажиллагаа бүх чиглэлээр хөгжиж байна. Дээд, өндөр хэмжээний айлчлалууд тогтмолжиж БНХАУ-ын төрийн тэргүүн, Монгол улсын Ерөнхий сайд, хоёр улсын Гадаад хэргийн болон бусад яамны сайд нар харилцан айлчлав.

Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг олон хэлбэрээр хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, байгалийн баялаг, дэд бүтцийг хөгжүүлэхэд хоёр улс анхаарч, Монгол улсын цаашдын ирээдүйн хөгжилд тус дэм болохуйц салбарт томоохон зээл тусламж, төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон билээ. Монгол улсын Засгийн газар нь БНХАУ-ын Засгийн газартай 1991 оны 8 дугаар сарын 26-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд эдгээр нь 1993 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон.

Хятад улс нь 2002 онд 53 тэрбум ам. долларын буюу хамгийн их гадаадын хөрөнгө оруулалт татаж чадсан орон (UNCTAD 2003) гэж тооцоогдож байгаагаас гадна сүүлийн жилүүдэд гадагшаа хөрөнгө гаргаж эхэлсэн байна. Үүнийг Монголд оруулж байгаа Хятадын хөрөнгө оруулалтын байдлаас харж болно. Хятадын хөрөнгө оруулагчид Монголд нийтдээ 379 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулсан нь Монголд орсон нийт гадаадын хөрөнгө оруулалтын 38 орчим хувийг бүрдүүлж байна.⁶

Хятадын бизнес эрхлэгчид 1990 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд 1993 оноос 1.4 сая ам. долларын, дараа дараагийн жилүүдээс энэ тоо хэмжээ өсөн нэмэгдэж 2001 онд 47.5 сая ам. долларт хүрч байжээ. Хятадын хөрөнгө оруулагчдаас Монголд хөрөнгө оруулах сонирхол өсөн нэмэгдэж байгааг үйл

⁶ Начин Д., 2004а, Гадаадын шууд хөрөнгө оруулалт: дэлхий нийтийн хандлага ба Монгол Улс, Олон Улс Судлал, # 1, 2004, 51-60 хуудас. ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэн

ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн компанийн тооноос харж болох юм. Тухайлбал, 1990 онд 1 компани, 1993 онд 12 компани бүртгүүлж байсан бол 1997 онд 73, 2002 онд 161 компани бүртгүүлсэн байна.

БНХАУ нь Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ болон хөрөнгө оруулалттай компанийн тоо зэрэг аль аль талаараа тэргүүлж буй орон. БНХАУ-ын хөрөнгө оруулагчид геологи уул уурхайн судалгаа, эрэл хайгуул, олборлолт /153.8 сая ам.доллар/, худалдаа, нийтийн хоол /92.5 сая ам.доллар/ инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /30 сая ам.доллар/, хөнгөн үйлдвэр /22.9 сая ам.доллар/, -ийн салбарт түлхүү хөрөнгө оруулалт хийгээд байгаа билээ.

Эдгээрээс “Эс энд Ти голд”, “Төмөртэй хүдэр”, “Доншен газрын тос Монгол”, “Баолинпетрохим” зэрэг компани геологи, уул уурхай, газрын тосны эрэл, хайгуул, судалгаа, олборлолтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа билээ.

“Богда холдинг”, “Зүйлун”, “Хуанчан” зэрэг компаниуд барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

“Монгол Хун Хуа”, “Топ лает текстиль”, “Олбьюти-Интернайшональ”, “МСХ интернэйшнл”, “Тианьпин гармент”, “Файвстар” зэрэг компани оёдлын үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байхад “Моннэхий-Импекс”, “Эрдос Монголия кашмир продактс” компани ноос, ноолуур боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байна.⁷

БНХАУ-ын төрийн тэргүүний айлчлалын үеэр Хятадын тал манай улсад 300 сая ам.долларын хөнгөлттэй зээл олгохоор болсоныг дагалдаж Хятадын талаас Монголд оруулах шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд 2003 онд 45 сая ам. долларт хүрсэн байна. Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр тогтвортой хөгжиж байна.

Монгол улсын гадаад бодлогод АНУ-тай харилцах харилцаа онцгой байр эзэлдэг бөгөөд АНУ-ыг “стратегийн түнш”-ээ гэж үзэж хоёр талын харилцаандаа шинэ алхмууд хийж, идэвхтэй байр суурь баримталж байна. 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагад өртсөн хүнд хэцүү үед АНУ-ын Ерөнхийлөгч Монгол улсын Ерөнхий сайдыг анх удаа хүлээн авч уулзсан, Монгол улсын Ерөнхийлөгч 2003 онд

⁷ Nachin D., 2004, *Foreign Direct Investment in Mongolia, ERINA REPORT. Vol. 58, 2004, pp.39-47*

АНУ-ын Ерөнхийлөгч болон бусад өндөр албаны хүмүүстэй чухал уулзалт хийсэн нь АНУ-ын төрийн бодлогод манай улсын орон зайг нэмэгдүүлж, хоёр орны харилцааг улам хөгжүүлэхэд ач холбогдолтой болов. АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Ричард Армитейжийн манай улсад хийсэн айлчлал нь Америкийн тал цаашид ч Монгол улстай нягт түншлэлийн харилцааг хөгжүүлж, ардчилал, зах зээлийн эдийн засгийг бэхжүүлэх талаар манай улсаас авч хэрэгжүүлж буй бодлогыг дэмжихээ дахин нотлосон юм.

Монгол улсын Засгийн газар нь АНУ-ын Засгийн газартай 1991 онд “Худалдааны харилцааны тухай”, 1994 оны 10 дугаар сарын 6-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т гарын үсэг зурсан бөгөөд энэ нь 1997 оны 4 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн АНУ-д 2004 оны 7 дугаар сард хийсэн айлчлалын үед Худалдааны ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурав.

АНУ-ын худалдааны департаментын Хятад-Монголын хэлтсийн дарга Монголд айлчилсан, Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн ээлжит XIII хуралдаан Вашингтон хотноо болсон, мөн Монгол-Канадын Гадаад хэргийн дэд сайд нарын түвшинд Оттава хотноо дугуй ширээний анхдугаар уулзалт зохиогдож Монголын худалдаа, хөрөнгө оруулалтын байдал, хоёр талын хамтын ажиллагааны талаар илтгэлүүд хэлэлцүүлсэн нь чухал арга хэмжээ боллоо. Хойт Америкийн хөрөнгө оруулагчид Монголд нийтдээ 247.3 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулсан Монголд орсон нийт гадаадын хөрөнгө оруулалтын дөрөвний нэг орчим хувийг бүрдүүлж байна(FIFTA 2004). Үүний 114.9 сая ам. долларыг нь АНУ-ын хөрөнгө оруулагчид, 132.5 сая ам. долларыг Канадын хөрөнгө оруулагчид оруулж, үйл ажиллагаагаа явуулахаар нийтдээ 120 гаруй компани бүртгүүлсэн байна.

Америкийн бизнес эрхлэгчид 1992, Канадын бизнес эрхлэгчид 1996 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхлэсэн бөгөөд 1996 оноос Хойт Америкийн хөрөнгө оруулагчид жилд дунджаар хорь орчим сая ам. долларын хөрөнгө Монголд оруулах болжээ. Эдгээр хөрөнгө оруулалтын дийлэнх нь геологи хайгуул, уул уурхай, газрын тос, оёдол, сүлжмэлийн үйлдвэрлэлд орсон байдаг.

Эдгээрээс “Вагнер-Ази” тоног төхөөрөмж, “Соко Тамсаг Монгол Инк” зэрэг компани геологи, уул уурхай, газрын тосны эрэл, хайгуул, судалгаа, олборлолтын “Эрдмин” компани катодын зэс үйлдвэрлэх салбарт үйл ажиллагаа явуулж байгаа билээ. “Соко Тамсаг Монгол Инк” компанийн бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу

олзворлон экспортлож байгаа түүхий нефтийн хэмжээ өсч байгаа бөгөөд 2003 онд 159498 баррель (4.5 сая ам. доллар)-д хүрсэн нь 2001 оны биет хэмжээнээс бараг 2 дахин их болжээ. Харин “Эрдмин” компани жилд дунджаар 1400 орчим катодын зэс экспортлож⁸ байгаа юм.

“Тин фар интернэшнл групп” компани оёдлын үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байхад “Монгол-Амикаль” компанийн үйлдвэрлэсэн “Гоёо” нэртэй тэмээний ноосон бүтээгдэхүүн манай хэрэглэгчдийн танил болсон байна. “Номадик Экспедишнз Монголиа”, “Аянчин аутфиттерс”, “Хөвсгөллоож” зэрэг компаниуд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж гадаадын, түүний дотор Хойт Америкийн жуулчдыг Монголтой танилцуулж байна. Хуулийн зөвлөгөө өгөх чиглэлээр ажилладаг “Линч энд махони” зэрэг компаниуд Хойт Америкийн болон бусад орны олон компани, хөрөнгө оруулагчдад Монголд хөрөнгө оруулах, бизнес эрхлэхэд нь туслаж дэмжсээр байгаа юм.

Хөдөөгийн бизнес эрхлэгчдэд зах зээлийн талын зөвлөгөө, туслалцаа үзүүлж байсан Говийн эхлэл компани өргөжин зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр болж байгаа нь сайшаалтай юм.

Сүүлийн үед мэдээлэл, компьютерийн чиглэлээр “Мэжикнэт”, “Инфокон” зэрэг компани байгуулагдан ажиллаж байгааг тэмдэглэхэд таатай байна.⁹

Энэ дашрамд АНУ, Канадын хөнгөлөлтийн системд Монголын экспортын зарим барааг хамруулах асуудал шийдэгдэх шатандаа байна гэдгийг дурдъя.

Япон улстай харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөн хүрээг хамарч, “иж бүрэн түншлэл”-ийн үзэл санааны дагуу хөгжиж байна. Японы Засгийн газар Монгол оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийг хоёр ба олон талын шугмаар тууштай дэмжиж Дэлхийн банкттай хамтран Монголд хандивлагчдын уулзалтыг 10 удаа зохион байгуулсан бөгөөд Монгол улсад үзүүлж буй зээл тусламжийн хэмжээгээр тэргүүлж байна. 1990 оноос хойш нийт хандивлагчдаас манайд үзүүлсэн зээл тусламжийн тэн хагас нь Японд ногдож байгаа юм. Японы Засгийн газар Монгол

⁸ Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар (ҮСГ), 2004, Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2003, ҮСГ, Улаанбаатар

⁹ Начин Д., 2004а, Гадаадын шууд хөрөнгө оруулалт: дэлхий нийтийн хандлага ба Монгол Улс, Олон Улс Судлал, # 1, 2004, 51-60 хуудас. ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэн

улстай ойрын 5 жилд хамтран ажиллах хөгжлийн албан ёсны тусламжийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхээр болов.

Монгол улсын Засгийн газар нь Япон улсын Засгийн газартай 2001 оны 2 дугаар сарын 15-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-г гарын үсэг зурсан нь Японы хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэх эрх зүйн үндэс, хүчин зүйл болсноос гадна Японы Itochu, Sumitomo, Nissho Iwai, Osaka Cashmere, Mitsubishi зэрэг компаниудын төлөөлөгчийн газар Монголд байгуулагдан ажиллаж байгаа нь ч чухал нөлөө үзүүлсэн.

2003 оны эцсийн байдлаар Японы хөрөнгө оруулагчид хамтарсан буюу дагнасан 167 аж ахуйн нэгж байгуулж, нийт 60.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн. Үүний ихэнх нь 58.3 хувь буюу 28.1 сая ам. доллар хөнгөн үйлдвэрийн салбарт ногдож байгаа бөгөөд хөнгөн үйлдвэрийн (сүлжмэл, ноолуур боловсруулах) салбарт хамгийн их /36.5 хувь/ хөрөнгө оруулжээ. Харилцаа, холбооны салбарт 8.1 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн нь салбарын хувьд мөн хамгийн их /48.4 хувь/ хөрөнгө оруулалт болж байна. 2003 онд Япон улс нь 6.8 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал бараг 2.5 дахин өссөн үзүүлэлт юм.¹⁰

Японы бизнес эрхлэгчид 1990 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын дийлэнх нь сүлжмэлийн үйлдвэрлэл, харилцаа, холбооны салбарт орсон байна. Эдгээрээс харилцаа холбооны үүрэн телефоны үйлчилгээг анх Монголд нэвтрүүлсэн Мобиком корпораци эдүгээ Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ, Налайх, Алтанбулаг, Замын-Үүд, Зуунмод, Багануур, Зүүнхараа, Сайншанд, Арвайхээр, Хархорин, Чойр, Булган, Хөтөл, Багахангай, Архангай, Өмнөговь, Хэнтий, Дундговь, Дорнод, Ховд, Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Сүхбаатар зэрэг хот аймгуудыг хамарсан үүрэн телефон холбооны сүлжээтэй ба нийт 200 мянга гаруй хэрэглэгчдэд 24 орон нутгийн үйлчилгээний салбар, Улаанбаатар хотод 10 гаруй үйлчилгээний төв, 40 гаруй гэрээт борлуулагчаар дамжуулан үйлчилгээ үзүүлж байна.

“Буян холдинг”, “Санширо” компани ноолуур боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэсэн ноос, ноолууран бүтээгдэхүүнээрээ манай хэрэглэгчдийн танил болсон байна.

¹⁰ Nachin D., 2001, Japanese Foreign Direct Investment in Mongolia, ERINA REPORT. Vol.40: 30-34, 2001. Niigata, Japan.

Монголд хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дахин хөрөнгө оруулж байгаа нь Монголд хөрөнгө оруулах боломж, бизнесийн үйл ажиллагаа явуулах муугүй нөхцөл байгааг харуулсан төдийгүй гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйл болж байна.

Японы хөрөнгө оруула Япон-лттай “Буянхолдинг”, “Мобиком”, “Суругамонгол”, “Санширо”, “Жэй Эм интернет моторс” компаниуд нь 2000-2003 онуудад 100 мянган ам.доллараас дээш хөрөнгө оруулалтыг харилцаа холбоо, ноолуурын үйлдвэрлэлд нэмж оруулснаас гадна гольфын тогмоомын үйл ажиллагаанд дахин хөрөнгө оруулсан байна.

Европын Холбоо, түүний гишүүн орнуудтай тогтоосон харилцааг бататгах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх үйл хэрэгт манай төр, засгийн удирдлагын түвшинд Европын Холбоо, түүний гишүүн улс болон Европын бусад улс болох Швейцарь, Украин, Туркт хэрэгжүүлсэн айлчлалууд чухал түлхэц боллоо.

Монгол улсын Засгийн газар нь Европын Холбооны 14 улс (ХБНГУ, ИБУИНВУ, Франц, Бельги/Люксембург, Итали, Унгар, Нидерланд, Дани, Польш, Чех, Австри, Литва, Швед)-тай “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, 11 улс (ХБНГУ, Унгар, Франц, ИБУИНВУ, Бельги, Чех, Польш, Люксембург, Нидерланд, Австри, Итали)-тай “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” гэрээнд гарын үсэг зурсан.

Монгол-Европын Холбооны хамтарсан хорооны VII хуралдаанаар худалдаа-хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Монгол улсыг Европын Холбооны АЛА хөтөлбөрт хамруулах, худалдаа-хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, тарифын хөнгөлөлт, зах зээлийн статустай болох зэрэг асуудлыг хэлэлцэв. Европын Холбооны техникийн хамтын ажилагааны ТАСИС хөтөлбөрөөс хөгжлийн туслалцааны АЛА хөтөлбөрт 2004 оноос шилжих болсон нь Европын Холбооны зүгээс Монголд хэрэгжүүлэх төслүүдийг илүү урт хугацаанд хэрэгжүүлэх, улмаар манай улсын цаашдын хөгжилд чухал хувь нэмэр үзүүлэх ач холбогдолтой юм. Энд Европын сэргээн босголт хөгжлийн банк манай улсыг зээлжих эрхтэй орнуудын тоонд оруулах шийдвэр саявтар гаргасныг тэмдэглэх нь зүйтэй.

2003 оны эцсийн байдлаар Европын Холбооны орнуудын хөрөнгө оруулагчид өссөн дүнгээр хамтарсан буюу дагнасан 264 аж ахуйн нэгж байгуулж, нийт 55 сая

ам.долларын хөрөнгө оруулалтыг хийжээ. Үүний 38.7 хувь буюу 21.3 сая ам.доллар Их Британийн хөрөнгө оруулагчдад, 19.5 хувь буюу 10.7 сая ам. доллар Италийн, 10.7 хувь буюу 5.9 сая ам.доллар ХБНГУ-ын хөрөнгө оруулагчдад ногдож байна. Салбарын хувьд хөнгөн үйлдвэрлэл (сүлжмэл, ноолуур боловсруулах)-д харьцангуй их хөрөнгө оруулжээ. 2003 онд Европын Холбооноос 5.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд энэ нь өмнөх оныхтой харьцуулбал 24 хувиар өссөн үзүүлэлт юм.

Европын Холбооны орнуудаас Их Британи, ХБНГУ-ын бизнес эрхлэгчид 1991-1992 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн байдаг.¹¹

2003 оноос Монгол-Германы Засгийн газар хоорондын Хөгжлийн хамтын ажиллагааны “Эдийн засгийн шинэчлэл, зах зээлийн эдийн засгийн хөгжил” тэргүүлэх чиглэлийн стратегийн баримт бичиг боловсруулан хэрэгжүүлж байна. Монгол, Германы Санхүүгийн хамтын ажиллагааны ээлжит хэлэлцээр, Сэргээгдэх эрчим хүчний нэгдүгээр хөтөлбөр, жижиг дунд үйлдвэрийн зээлийн хөтөлбөрийн дагалдах арга хэмжээ, судалгаа, мэргэжилтний сан, Төрийн Хянан Шалгах Хорооны чадавхийг бэхжүүлэх, жижиг дунд үйлдвэрүүдэд зөвлөгөө өгөх зэрэг 15 сая орчим еврогийн техникийн болон санхүүгийн хамтын ажиллагааны төслүүдийн гэрээ, хэлэлцээр байгуулагдав.

Монгол-Австрийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын хурал, Монгол-Италийн ажил хэрэгч хүмүүсийн уулзалт, Монгол-Чехийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын анхдугаар хуралдаан болж, хоёр талын худалдаа-эдийн засгийн харилцааны өнөөгийн байдлын талаар хэлэлцэв. Монгол улсын Ерөнхий сайд Шведийн Вант улсад албан ёсны айлчлал хийх үедээ хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож Монгол улсын Засгийн газар, Шведийн Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд “Дамжуулалтын сүлжээний шинэчлэл ба сэргээн сайжруулалт” зээлийн төслийн харилцан ойголцлын санамж бичигт гарын үсэг зурсан болно. Түүнчлэн “Нордикийн хөгжлийн сан”, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Боловсролын

¹¹ Начин Д., 2004б, Гадаадын хөрөнгө оруулалтыг татах ба Европын холбооноос Монголд хөрөнгө оруулсан байдал, Эдийн Засаг, # 2, 2004, 21, 27-28 хуудас, Монголын эдийн засаг, бизнесийн холбоо, Улаанбаатар, Монгол улс

салбарын хөгжлийн хөтөлбөр”, “Нийгмийн салбарын хөгжлийн хөтөлбөр”, “Тээврийг хөгжүүлэх төсөл” зэрэг зээлийн төслүүд амжилттай хэрэгжиж байна.

Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтоогоод 10 гаруйхан жил болж байгаа ч найрсаг харилцаа, нийгмийн амьдралын бүхий л салбарт эрчимтэй хөгжиж, эдүгээ хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа харилцан бие биеэ нөхсөн шинжтэй болж өргөжин хөгжиж байна. Дээд, өндөр хэмжээний айлчлалууд тогтмолжиж, БНСУ манай орны хувьд дөрөв дэх том хөрөнгө оруулагч бөгөөд худалдааны эргэлтээрээ эхний тавд ордог гол түнш орны нэг болоод байна. Монгол-Солонгосын харилцааны нэг онцлог бол тус улсад манай 17 мянга орчим иргэд ажиллаж, амьдарч байгаа билээ. Түүнээс гадна манай улсад Солонгосын хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд нэмэгдэж эдүгээ БНСУ-ын нийт хөрөнгө оруулалт (80.8 сая ам. доллар)-ыг салбараар авч үзвэл, уул уурхайн салбарт 16% (буюу 12,9 сая ам.доллар), худалдаа нийтийн хоолны салбарт 12,7% (10,2 сая ам.доллар), хөнгөн үйлдвэрийн салбарт 8,3% (6,7 сая ам.доллар), тээврийн салбарт 7,1% (5,7 сая ам.доллар), харилцаа холбооны салбарт 6,6% (5,3 сая ам.доллар), инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт 5,3% (4,3 сая ам.доллар) тус тус орж (FIFTA 2004), худалдаа, үйлчилгээ, тээвэр, хөнгөн үйлдвэрийн салбар компанийн тоогоороо тэргүүлж байна. Монголд хөрөнгө оруулалт хийсэн Солонгосын томоохон хөрөнгө оруулагчдаас Тай-Үл, Кореа Телеком, Самик, СК Телеком, Тү Март зэрэг корпорациудыг дурьдаж болох юм.

БНСУ-ын хөрөнгө оруулагчид 1994 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд сүүлийн үед үйлдвэрлэл, үйлчилгээний олон салбарыг сонирхон хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсээр байгаа болно. 2003 онд БНСУ-ын хөрөнгө оруулагчид нийт 125 компани 6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр бүртгүүлээд байна. БНСУ-аас хийгдэж буй шууд хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тогтвортой өсөн нэмэгдэж буй нь манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжин тэлж буйг нотолж байгаа бөгөөд цаашдаа ч хөрөнгө оруулалт, бизнесийн хүрээнд хамтарч ажиллах боломж нээлттэй байгааг харуулж байна.

Эдгээрээс харилцаа холбооны үүрэн телефоны “Скайтел” компани нь эдүгээ нийт хэрэглэгчдийн гуравны нэг орчимд үйлчилгээ үзүүлж байна. “Трост энд Глори”, “Волдтрейдинг” зэрэг компани оёдлын үйлдвэрлэлд үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гадаад зах зээлд гарч байна.

Монгол улсын Ерөнхий сайд БНСУ-д албан ёсоор айлчлах үеэрээ “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай” хоёр орны засгийн газар хоорондын хэлэлцээрт 1991 оны 3 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурж мөн оны 4 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон нь БНСУ-ын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн үндэс, хүчин зүйл болсон байна.

Монгол улсын Засгийн газраас ийнхүү Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэх тодорхой үйл ажиллагаа явуулж ирсний үр дүнд Монголыг сонирхох, тухайлбал хөрөнгө оруулагч улс орны тоо ч өсөн нэмэгдэж байна. 1990 онд зөвхөн 2 орны хөрөнгө оруулагч Монголд үйл ажиллагаа эрхэлж байсан бол 1994 онд өссөн дүнгээр 20, 1996 онд 41, 2000 онд 65, 2003 онд 73 орны хөрөнгө оруулагчид Монголд үйл ажиллагаа эрхэлэхээр бүртгүүлээд байна.

Хөрөнгө оруулагчдын харъяалагдах улс орноор авч үзвэл Зүүн Хойд Ази, Хойд Америкийн хөрөнгө оруулагчид түлхүү хөрөнгө оруулалт хийснээс БНХАУ-ын хөрөнгө оруулагчид Монголд орсон гадаадын хөрөнгө оруулалтын 37.9 хувиар хөрөнгө оруулагчдын жагсаалтыг тэргүүлж, Канад улс 13.2 хувиар удаалж, АНУ(11.4%), БНСУ(8.1%), Япон(6.0%), ОХУ(3.3%) болон бусад орны (20.1%) хөрөнгө оруулагчид дараагийн байруудад орж байна.¹²

Монгол улсад одоогийн байдлаар 1990 оноос хойш өссөн дүнгээр 1.14 тэрбум ам.долларын хөрөнгө гадаадын улс орнуудаас бүртгэгдсэн бөгөөд зөвхөн 2000-2004 онд үүний гуравны хоёр орчим буюу 730 сая гаруй ам.доллар орсон байна. 2003 онд нийтдээ 205.2 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орсон нь 1996-1999 оны дунджаас бараг 4 дахин их байна.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь одоогийн байдлаар өссөн дүнгээр 70 гаруй мянган ажлын байр бий болгож, сүүлийн жилүүдэд Монголын нийт экспортын тал орчим хувийг гүйцэтгэж, төсөвт 40 орчим тэрбум төгрөгийн татварын орлого оруулж байгаагаас гадна үйлдвэрлэл, үйлчилгээний бусад салбар (цахилгаан, дулаан, холбоо, тээвэр зуучийн гэх мэт)-ыг ч дэмжиж байна.

¹² Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА) 2004, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тойм 2002, 2003. ГХОГХА, Улаанбаатар

¹³ Гадаад хэргийн яам (ГХЯ), 2004, Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны салбарын 2000-2004 оны үйл ажиллагааны тухай сайд Л.Эрдэнэчулуунаас сэтгүүлчдэд хийсэн мэдээлэл, 2004.03.16., Улаанбаатар

Ийнхүү Монголын төр, засгаас сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулан татахад шууд чиглэсэн гадаад бодлого, холбогдох арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг бэхжүүлэх бодит үндэс суурь болж, Монгол Улсад хийгдэж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт жилээс жилд өсч, эдүгээ ДНБ-ний бараг 20 хувьтай тэнцэх хэмжээнд хүрээд байгааг дараахи хүчин зүйлүүдтэй холбож болохоор байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулагчдын хэзээд болгоомжилдог байсан Монголын төсөвт санхүүгийн тооцоолоогүй дарамт гарч ирэн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэх нэгэн “эрсдэл” Монгол улс, ОХУ-ын хооронд он дамжин яригдсаар ирсэн “их өрийн” асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн нь.¹³
- Монгол улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд өсөх хандлага тогтворжин ДНБ-ий өсөлт 2003 онд 5.5 хувьд хүрсэн тул 2003 оны 11 дүгээр сард Токио хотноо зохиогдсон Монголд хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалтаас манай орныг шилжилтийн үеэс өсөлтийн үед шилжсэн гэж дүгнэсэн.¹⁴
- НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас хийсэн судалгааны үр дүн болох 2003 оны Дэлхийн хөрөнгө оруулалтын тайланд Монгол Улс нь ГШХО орох өндөр чадавхтай орнуудын тоонд багтсан.¹⁵
- Нөгөөтэйгүүр Европ, Америк төвтэй дэлхийн уламжлалт зах зээл Ази, тэр дундаа БНХАУ руу чиглэн шилжиж байгаа үед энэхүү том зах зээлд нэвтрэх

¹⁴ The Asian Development Bank (ADB) 2003, Report on the tenth consultative group meeting on Mongolia, Tokyo, November 19-21, 2003. ADB. <http://www.adb.org/Documents/Conference/IN309-03.pdf>

¹⁵ United Nations Conference on Trade and Development (UNCTAD), 2003, World Investment Report 2003: FDI Policies for Development: National and International Perspectives, United Nations, New York and Geneva, 2003

¹⁶ Цогтбаатар Д., 2004, Монгол, Туркийн бизнесийн төлөөлөгчдийн уулзалт дээр Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Д.Цогтбаатарын хэлсэн үг, Измир хот, 2004 оны 5 дугаар сарын 1, Измир хот, Турк улс. www.extmin.mn/medee040501.html

* Нэмэлт өөрчлөлт оруулан 2002 онд баталсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 2.2 заалтаар “...гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог судлах, гадаад сурталчилгааны ажлыг зохион байгуулах ...” эрх үүргийг Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт хүлээлгэсний дагуу тус агентлаг нь Монгол Улсын

үүднээс гадаадын хөрөнгө оруулагчдад худалдааны либерал бодлого, тогтолцоотой Монголыг сонирхох сонирхол нэмэгдсэн явдал юм.¹⁶

Иймд цаашид Монголд бизнес эрхлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах таатай орчин бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхийн сацуу улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад сурталчилгаанд^{*} улам илүү ач холбогдол өгөх нь ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтын төлөө өрсөлдөөн нэмэгдэж байгаа, манай орны зах зээл, эдийн засгийн хэмжээ бага зэрэг хүчин зүйлээс шалтгаалан зайлшгүй шаардлага бий болоод байна. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхой салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээний салбарт нарийвчлан хандуулах, шинэ дэвшилтэт технологи дамжуулан авах^{*}, нутагшуулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарах нь чухал^{*}.

¹⁶ Цогтбаатар Д., 2004, Монгол, Туркийн бизнесийн төлөөлөгчдийн уулзалт дээр Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Д.Цогтбаатарын хэлсэн үг, Измир хот, 2004 оны 5 дугаар сарын 1, Измир хот, Турк улс. www.extmin.mn/medee040501.html

^{*} Нэмэлт өөрчлөлт оруулан 2002 онд баталсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 2.2 заалтаар "...гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог судлах, гадаад сурталчилгааны ажлыг зохион байгуулах ..." эрх үүргийг Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт хүлээлгэсний дагуу тус агентлаг нь Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарууд, хөрөнгө оруулалтын боломж, эрх зүйн орчинтой танилцуулах, улмаар ГШХО-ыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт зохион байгуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бусад үйл ажиллагааны үндсэн чиглэлээр ажиллаж байна.

^{*} Монгол Улсын Улсын Шинжлэх ухааны технологийн, Технологи дамжуулах, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын, Нэмэгдсэн өртгийн албан татварын, Гаалийн тарифын зэрэг хуулиудад шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт, дамжуулах технологи, татвараас чөлөөлөх, хөнгөлөх нөхцлүүдийг тодорхой заасан байдаг боловч Технологи дамжуулах үйл ажиллагаа учир дутагдалтай байна.

^{*} УИХ-ын 1994 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д ...экспортын болон хүнсний нөөцийг нэмэгдүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөхүүлэн дэмжих, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэл хөгжүүлэх чиг баримтлах, ...оюуны бүтээлийг баталгаажуулах, гадаадын технологийг Монголын нөхцөлд тохируулан нэвтрүүлэх эрх зүйн баталгааг бүрдүүлэх,...үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэхэд амжилт гаргаж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгодог зарчим баримтлах зэрэг чухал заалтууд тусгагдсан байдаг.

Mongolia's joining to international multilateral conventions and treaties on economic and technical cooperation and establishing bilateral treaties on investment promotion protection and double taxation avoidance based on National Security and Foreign Policy concepts and Diplomatic service law of Mongolia have being creating a favorable foreign legal investment environment to attract foreign direct investment (FDI) into Mongolia. FDI has being increasing and reached US\$205 million in 2003 and cumulative value over one US billion\$ since 1990 as of the end of 2003. Leading investor-countries are PRC, Canada, USA, ROK, Japan and Russia.